



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/308

Номгон

Г Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай Г


Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4, 16 дугаар зүйлийн 16.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Баянхонгор сумын “Өлзийт буянт хийморь” ХХК-ний Өлзийт, “Ханхарын баян тал” ХХК-ний Баянтал, “Баялаг тайхар” ХХК-ний Тайхар, “Оргилох мөнгөн Ундарга” ХХК-ний Баян-Ундарга хүнсний дэлгүүрүүдийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2029 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн захирал Э.Цэрэнчимэг, Л.Өлзийжаргал, Б.Батмөнх, Г.Юмжирмаа нарт, холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624010747